



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 389

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй 24,000,000.00 (хорин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, 11,867,551.04 (арван нэгэн сая найман зуун жаран долоон мянга таван зуун тавин нэгэн төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний өрөнхий газрын дарга Б.Нямдаваа, Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах; 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

Автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН


ХЭЛТСИЙН ДАРГА

Э.Гаваа

Б.ГАВАА

0002200

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн
...³⁸⁹ дугаар тогтоолын хавсралт



Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ЫН 2018 оны 213 дүгээр тогтоолоор тогтоосон дуудлага худалдааны доод үнэ (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ (төгрөг)
1	Старекс, 53-44 БУЛ, арал №40587568	2004/ 2012	24,000,000.00	9,700,000.00	1,000,000.00
	Нийт дүн		24,000,000.00 (хорин дөрвөн сая)	9,700,000.00 (есөн сая долоон зуун мянган)	1,000,000.00 (нэг сая)